УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга *1*

Хуралдааны товч тэмдэглэл: *2-3*

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: *4-5*

1.Байнгын хорооны дарга сонгох тухай *4-5*

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 11 дүгээр сарын 28-ны өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Г.Мөнхцэцэг ирц, хэлэлцэх асуудлын дараалыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 02 минутад Төрийн ордны "Их засаг" танхимд эхлэв.

Томилолттой: Г.Дамдинням, Л.Энх-Амгалан;
Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, С.Чинзориг.

Нэг.Байнгын хорооны дарга сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байгаа талаарх саналыг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасны дагуу санал хураалт явуулав.

Г.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргаар сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 1
Бүгд: 12
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах *санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 05 минут үргэлжилж, 16 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 07 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Г.МӨНХЦЭЦЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр, Мягмар гараг Төрийн ордон "Их засаг" танхим 12 цаг 02 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Мөнхцэцэг: *Байнгын хорооны эрхэм гишүүдийн өнөөдрийн амгаланг айлтгая.*

Боловсрол, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны өнөөдрийн хуралдаанд ирвэл зохих 16 гишүүн ирсэн байхаас 12 гишүүн ирсэн тул Байнгын хорооны ирц бүрдэж өнөөдрийн хуралдааныг эхэлье ээ.

Өнөөдрийн хуралдаанаар нэг асуудал хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудал байна.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцье.

Байнгын хорооны даргад Байнгын хорооны гишүүдийн дотроос олонхын саналаар нэр дэвшүүлэх ийм дэгтэй.

Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгээс Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх талаар танилцуулгыг хийнэ ээ.

Бат-Амгалан гишүүнийг микрофонд урьж байна.

Бат-Амгалан гишүүний микрофоныг өгье.

Э.Бат-Амгалан: *Баярлалаа. Байнгын хорооны гишүүд та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. БСШУС-ын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай МАН-ын бүлгээс танилцуулга хийе ээ.*

Байнгын хорооны даргад Балжиннямын Баярсайханыг гишүүдийн олонх дэмжиж, Байнгын хороонд танилцуулж байна. Баярсайхан гишүүний намтрыг та бүхэндээ уншиж танилцуулъя.

Гэр бүлийн байдал Нөхөр 4 хүүхдийн хамт амьдардаг.

Төгссөн сургууль, мэргэжил. 1987 онд Нийслэлийн 51 дүгээр дунд сургууль, 1991 онд Багшийн сургуулийн хөгжмийн анги, багш, 1998 онд МУИС-ийн Хууль зүйн дээд сургууль эрх зүйч, 1999 онд Монголын хэвлэлийн хүрээлэнд сэтгүүлч, 2004 онд Удирдлагын академи Нийгмийн ухааны магистр.

Мэргэжил дээшлүүлсэн байдал.

2000 онд Ирландын Даблин хотын Англи хэлний сургууль, АНУ-ын Вашингтон хотын Үндэсний Их Сургууль, 2006 онд Израилын ГХЯ-ны дэргэдэх сургууль, 2012 онд АНУ-ын Хавай мужийн Хагая олон улсын удирдлагын сургууль тус тус мэргэжил дээшлүүлсэн.

Ажилласан байдал.

1995-1997 онд МҮОНТ-д хөтлөгч, редактор, 1997-2000 онд Монгол Улсын Дээд шүүхэд хэвлэлийн төлөөлөгч, 2000-2002 онд MCS группд PR менежер, 2002-2004 онд Ийгл телевизийн Борлуулалт маркетингийн албаны дарга, 2004-2014 онд Ийгл телевизийн гүйцэтгэх захирал, 2015-2016 онд олон улсын пресс клубүүдийн холбооны ерөнхийлөгч, 2016-2020 онд БСШУСЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, 2020 онд Монгол Улсын ерөнхий сайдын зөвлөх, 2020 оноос Монгол

Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна аа.

Шагнал

Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн хэвлэл мэдээллийн тэргүүний ажилтан, Монголын үйлдвэр худалдаа аж үйлдвэрийн танхимын Сайн засаглалыг хэрэгжүүлэх шилдэг интерпрёнер удирдах шагнал, Үндэсний өгөх өдөр Хүмүүнлэгийн хөдөлгөөнийг санаачлагч, АНУ-ын хүүхдийн хүчирхийллийн эсрэг Глобал нэгдэл байгууллагын хүүхдэд ээлтэй хүн шагнал, гадаад хэл Англи гэсэн ийм намтартай гишүүнийг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэхээр МАН-ын бүлгээс оруулж байна аа.

Дэмжиж өгөхийг эрхэм гишүүдээс хүсье ээ. Баярлалаа.

Г.Мөнхцэцэг: *Бат-Амгалан гишүүнд баярлалаа.*

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх талаар өөр саналтай гишүүн байна уу? Алга байна. Байнгын хорооны даргад нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Байнгын хорооны дарга болон нэгдсэн хуралдаанд гишүүдээс нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно оо гэсэн ийм дэгтэй. Үг хэлэх гишүүн байна уу? Үг хэлэх гишүүн алга байна. Гишүүд асуулт асууж, үг хэлэх гишүүд байхгүй байгаа учраас санал хураалтдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Балжинням овогтой Баярсайханыг БСШУС-ын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны дарга хорооны дарга сонгох асуудлын санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулна.

Санал дүгнэлтийг би өөрөө уншчих уу? Мөнхцэцэг гишүүн уншина аа.

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдөр хуралдаанд оролцсон та бүхэнд баярлалаа. Хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА